

Хятадад суралцдаг монгол оюутнуудын соёл дамнасан хэлний дасан зохицох байдалд хийсэн судалгаа

Zhang Ruifang

Yang Yisheng

(ӨМБИС, Олон улсын харилцааны сургууль; ӨМБИС, Сэтгэл судлалын судалгааны төв, Өвөрмонгол Хөх хот 010022)

Хураангуй: Өөрийн боловсруулсан гадаад оюутнуудын соёл дамнасан хэлний дасан зохицлын талаарх асуулгаа ашиглан хятадад суралцдаг монгол оюутнуудын хятад хэлэнд дасан зохицох байдалд байгаа онцлог болон түүнд нөлөөлж буй хүчин зүйлүүдэд дүн шинжилгээ хийсэн болно. Судалгааны дүнгээс харахад, хятадад суралцаж буй монгол оюутнуудын хэлний дасан зохицох байдал нь тархалтын хувьд хэвийн хэмжээнд, хэлний нийт дасан зохицох байдал нь дундаас дээгүүр түвшинд байгаа бөгөөд тэдний нас, хүйс, боловсролын түвшин, мэргэжил, нийт хятад хэл суралцсан хугацаа болон хэлний түвшин, гэр бүлийн эдийн засгийн байдал, багш суралцагчдын харилцаа болон хятад найз нөхдийн тоо зэрэг нь соёл дамнасан хэлний дасан зохицох байдалд тодорхой хэмжээний нөлөөлөл үзүүлдэг байна.

Түлхүүр үг: монгол оюутнууд, хэлний дасан зохицох байдал, соёл дамнах

Зургийн DIO: G444

Өгүүллэгийн зэрэглэл: A

Өгүүллэгийн дугаар: 1671-0916(2015)09-0082-04

Нэг. Удиртгал

Соёл дамнасан хэлний дасан зохицох байдал гэдэг нь тодорхой нэгэн соёлын нөлөөнд байсан хүн өөр соёл руу шилжих явцад бие махбодь болон сэтгэл санаанд гарч буй бүхий л хариу үйлдэл явцыг нэрлэнэ. (Sam & Berry, 2006). Соёл дамнасан хэлний дасан зохицох байдлын судалгаа нь 20-р зууны эхэн үеийн АНУ-аас эхтэй бөгөөд хамгийн анх Америкийн антропологист дэвшүүлэн тавьсан байна. Соёл дамнасан дасан зохицох үзэгдэл нь олон шат дамжлага бүхий ээдрээтэй байдаг тул салбар салбарын судлаачид өөр өөрийн өнцгөөс асуудлыг харж харилцан адилгүй үзэл санаануудыг дэвшүүлдэг нь маш олон онолын сургуулиудыг гаргаж ирэхэд хүргэдэг. Нэлээд олон төрлийн соёл дамнасан дасан зохицох байдлын онолууд дундаас соёл дамнасан хэлний дасан зохицох үзэгдэл нь маш ихээр хөндөгдөж хэлэлцдэг сэдэв юм. 20-р зууны 70-аад онд Goiles зэрэг хүмүүс хэлний дасан зохицох байдлын онолыг дэвшүүлсэн (speech Accomodation Theory) ба анх нийгмийн сэтгэл судлалын онолын загвараар гарч ирсэн. Энэ онолоор хамгийн гол нь харилцааны явц дахь хүмүүсийн сэтгэл хөдлөлийн мотивацийг тайлбарладаг бөгөөд түгэн дэлгэрсээр хэл соёлын маш өргөн хүрээнд яригдах болсон төдийгүй гадны олон хэл шинжээчид хэлний дасан зохицох байдлын онолыг ашиглан цагаачдын бүс нутаг, хос хэлтэй болон олон хэлтэй бүс нутгуудад судалгаа явуулдаг байна. Хэл бол нийгэм соёлын бүтээгдэхүүн тул нийгмийн бүтэц болон соёлын өөрчлөлтийг дагаад хэл болон бусад хэлний үйлүүд ч мөн зайлшгүй өөрчлөгддөг билээ. Verschueren-ий хэлний дасан зохицох онол нь танин мэдэхүй, нийгэм болон соёлын талаас харж хэл болон хэлний дасан зохицох байдалд цогц судалгаа хийсэн бөгөөд энэ үзлээр бол хэлний

дасан зохицлыг хоёр тал руу чиглэсэн интерактив шинжтэй гэж тайлбарлажээ. Хэл бүхэлдээ хэлний орчны ямар нэгэн нөлөөнд орвол түршлагадаа тулгуурлан аливаа сонголт эсвэл хариу үйлдлийг үзүүлж үүнийгээ шинэчилсээр эцсийн дасан зохицох байдалд хүрдэг. Хоёрдогч хэлийг суралцахад ч гэсэн эх хэлний бүтэц дээр суурилан зорилтот хэлний хэл болон түүний соёлын талаар ойлголттой болдог. Хэл болон орчин нэгдмэл болсон нөхцөлд л соёлын мэдлэг, мэргэжлийн техник болон сэтгэлгээний системийг үр дүнтэйгээр эзэмших боломжтой болдог.

Даяарчлал хурдацтай явагдаж байгааг дагаад хятадад суралцдаг гадаад оюутнууд боловсролын цар хүрээ, түвшин, чанар мэдэгдэхүйц өссөөр байгаа билээ. Хятадад ирж суралцаж байгаа ихэнхи оюутнуудын хамгийн түрүүнд тулгардаг асуудал нь хэлний дасан зохицох байдал юм. Ялангуяа хятад хэл болон хэлний орчны нарийн түвэгтэй байдал нь оюутнуудын хэлний дасан зохицох байдалд хүндрэл учруулдаг. Маш олон гадаад оюутнууд, Хятадад ирээд хамгийн түрүүнд тулгардаг томоохон асуудал нь хятад хүмүүстэй харилцах болон хятад хэлээр өдөр тутмын ажил хэргээ зохицуулах явдал байдаг гэдгийг дурдсан байна. Иймээс, соёлын ялгаанаас үүдэлтэй хэлний дасан зохицох байдлын талаарх асуудал нь оюутнуудад үргэлжлүүлэн суралцахад нь чухал нөлөө үзүүлдэг юм. Өнөөгийн байдлаар гадаад оюутнуудын хэлний дасан зохицох байдалд хийсэн судалгаа харьцангуй бага байгаа бөгөөд тус судалгааны ажлаар тохирох аргыг ашиглан Өвөрмонголд ирж суралцаж байгаа монгол оюутнуудын соёл дамнасан хэлний дасан зохицох байдалд цогц судалгаа хийж, хятадад суралцдаг монгол оюутнуудын соёл дамнасан хэлний дасан зохицох байдлын онцлог болон түүнд нөлөөлөх хүчин зүйлүүдийг судлахыг оролдлоо.

Хоёр. Судалгааны арга

1. Түүвэрлэх

Тус судалгааны ажлын тоо баримтыг “Өвөрмонголд суралцдаг монгол оюутнуудын соёл дамнасан дасан зохицох байдлын судалгаа” төслөөс авсан. Тус төсөл нь Өвөрмонголд суралцдаг монгол оюутнуудаас нийт 16-40 насны 175 хүнийг түүвэрлэн авч судалгаанд хамруулсан. Судалгаанд ӨМБИС, ӨМИС, өвөрмонголын аж үйлдвэрийн их сургууль, өвөрмонголын анагаах ухааны их сургууль, Хөлөнбуйрын дээд сургуулийн хятад хэл, утга зохиол, хятад хэл заах арга, мэдээ, орчуулга, түүх, хууль, газарзүй, боловсрол судлал, сэтгэл судлал, удирдлага, эдийн засаг, биологи, математик, физик, хими, барилга, механизм, цахим компьютер, шинжлэх ухааны түүх, нийгэм судлал, хүн судлал, уран сайхан зэрэг мэргэжлийн хүмүүс хамрагдсан. Тэд харилцан адилгүй нөхцөлд 6 сараас 7 жил хүртэлх хугацаанд хятад хэл суралцсан бөгөөд тэдний 60 нь эрэгтэй, 115 нь эмэгтэй, бакалаврын түвшний боловсролтой 68 хүн, магистр болон докторын зэрэгтэй 107 хүн, түүх, уран зохиолын чиглэлийн 57, эдийн засаг, менежментийн чиглэлийн 52, аж үйлдвэрийн чиглэлийн 66 хүн, хятадын засгийн газрын тэтгэлэгт хамрагдсан 111, өвөрмонголын засгийн газрын тэтгэлэгт хамрагдсан 41, хувийн зардлын 23 хүн зэрэг болно.

2. Хэмжилтийн хэрэглэгдэхүүн

Тус судалгааны ажил нь өөрийн боловсруулсан “Гадаад оюутны соёл дамнасан хэлний дасан зохицох байдлын асуулга”-г ашигласан. Уг асуулга нь гадаад оюутны шинэ соёл дахь хэлний дасан зохицох чадварыг илрүүлэх зорилготой нийт 13 асуулттай. Үүнд “хичээлийн танхимд

багшийн зааж байгаа агуулгыг бүрэн ойлгодог”, “хятад хүмүүстэй хятад хэлээр ойлголцдог”, “хятад хүмүүсийн биеийн хэлийг ойлгодог болсон” зэрэг хятад хэлийг суралцах явцад тулгардаг төрөл бүрийн хэлний үйлүүдийг тусгасан. Асуулгаар дамжуулан унших, сонсох чадварын дасан зохицол, бичих чадварын дасан зохицол, ярианы бус чадварын дасан зохицол, хичээлийн танхим дах хэлний дасан зохицол гэсэн 4 бүлгийн хүчин зүйлийг гаргасан. Унших, сонсох чадварын дасан зохицох байдлыг оюутнуудын ном сэтгүүл унших, интернэт орчинд ажиллах, кино үзэхболон хятад хэлээр харилцах байдалд дасан зохицож байгаа байдлаар, бичих чадварын дасан зохицох байдлыг оюутнуудын ханз бичих, өгүүлбэр бичих, нийтлэл бичих зэрэгт дасан зохицож байгаа байдлаар, ярианы бус чадварын дасан зохицох байдлыг оюутнуудын үгийн өнгө, өргөлт, дуудлага, нүүрний хувирал, гарын хөдөлгөөн, хандлага зэрэгт дасан зохицож байгаа байдлаар, хичээлийн танхим дах хэлний дасан зохицох байдлыг оюутнуудын танхимд хятад хэлээр өөрийгөө илэрхийлэх байдал, багшийн яриаг сонсох болон хоорондоо харицлах зэрэгт дасан зохицож байгаа байдлаар илрүүлсэн. Асуулгад liket оноо тооцох аргыг ашиглан 1 буюу “хэцүү биш” гэдгээс 5 буюу “маш хэцүү” гэсэн байдлаар оноо тооцсон бөгөөд оноо өсөх тусам хэлний дасан зохицох түвшин өснө гэсэн үг юм. Хүснэгт 1-т үзүүлснээр тус асуулгын 4 бүлэг дах а итгэлцүүр нь 0,688-0,802 байгаа бөгөөд нийт агуулгын уялдааны итгэлцүүр 0,88 байгаа нь тус асуулгын үр дүн нь харьцангуй итгэж болохуйц бөгөөд соёл дамнасан хэлний дасан зохицох түвшинг тодруулж болно гэдгийг харуулж байна.

Хүснэгт 1 Хятадад суралцдаг монгол оюутнуудын хэлний дасан зохицох байдлын асуулгын хэмжилтын үр дүн

Нийт асуулга	унших, сонсох чадвар	бичих чадвар	ярианы бус чадвар	танхимийн хэл	
α 系数	0.880	0.796	0.802	0.688	0.696

3. Судалгааг явуулах болон тоо баримтыг нэгтгэх

Уг судалгааг гадаад оюутанд хятад хэл зааж байсан туршлагатай багшаар хөтлүүлж, групп байдлаар нийт 20 минутын хугацаанд судалгааг авсан. Тоо баримтыг SPSSI 16.0 –г ашиглан нэгтгэсэн.

Гурав. Судалгааны үр дүн

1. Хятадад суралцдаг монгол оюутнуудын соёл дамнасан хэлний дасан зохицох байдлын ерөнхий түвшин

Хүснэгт 1-т үзүүлснээр хятадад суралцдаг монгол оюутнуудын соёл дамнасан хэлний дасан зохицох байдлын дундаж нь 4.4743-3.8971 хооронд буюу нийт дундаж 3.6993 байна. Стандарт зөрүү нь 0.75715-0.93664 хооронд буюу ерөнхий зөрүү нь 0.66649 байна. Дундаж тооноос харахад, дунджаас дээгүүр байгаа нь монгол оюутнуудын хэлний дасан зохицох түвшин дундаас дээгүүр түвшинд байгааг харуулж байна. Түүнээс дасан зохицох байдал хамгийн сайн нь танхим дах хэлний хэрэглээний чадвар, хамгийн сул байгаа нь ярианы бус хэлний чадамж байна. Хүснэгт 2-оос бүлэг тус бүрийн нийт итгэлцүүр дэх хамгийн их болон бага утга нь 1-ээс байга байгаа нь хятадад суралцдаг монгол оюутнуудын соёл дамнасан хэлний

дасан зохицох байдал нь хэвийн тархалттай байгааг харуулж байна. Энэ нь судалгаанд оролцогчдын ихэнхи нь хэлний дасан зохицох байдлын дунд түвшинд байгааг мөн харуулж байна.

Хүснэгт 2. Хятадад суралцдаг монгол оюутнуудын соёл дамнасан хэлний дасан зохицох байдлын статистик мэдээ

	Хамгийн бага	Хамгийн их	Дундаж	Статистик зөрүү	Муруйн хамгийн бага	Муруйн хамгийн их
Унших, сонсох	1.8	5	3.6697	0.75715	-0.105	-0.719
Бичих	1.33	5	3.8419	0.83262	-0.558	-0.18
Ярианы бус	1.33	5	3.4743	0.87271	-0.243	-0.671
Танхимын хэл	1	5	3.8971	0.93664	-0.647	-0.158
Нийт	2	4.92	3.6993	0.66649	-0.108	-0.549

2. Хятадад суралцдаг монгол оюутнуудын соёл дамнасан хэлний дасан зохицох байдалд нөлөөлөх дотоод хүчин зүйлс

Нас, хүйс, боловсролын түвшин, мэргэжил, хятад хэлний түвшин зэрэг дотоод хүчин зүйлсийн хоорондын зөрүүтэй байдалд хийсэн судалгааг Хүснэгт 3—аас харна уу. Үр дүнд харуулснаар, Монгол оюутнуудын хувьд хэлний дасан зохицох байдлын нийт оноонд хүйсийн ялгаа мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх ба эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илт давуу байгаа нь эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийг бодвол хэлний дасан зохицох түвшин нь харьцангуй өндөр байна. Танхимын хэлний дасан зохицох байдалд насны зөрүүтэй байдал нь нөлөө үзүүлж байгаа ба 20-с бага, 30-с дээш насны хүмүүсийн танхимийн хэлэнд дасан зохицох байдал нь бусад насныхнаас илт өндөр байна. Ярианы бус хэлний дасан зохицох чадварт боловсролын зэргийн нөлөө харьцангуй их байгаа буюу бакалаврын түвшний оюутнуудын ярианы бус чадварын дасан зохицох түвшин магистрын зэргийн оюутнуудаас өндөр байна. Унших, сонсох, бичгийн болон ярианы бус чадварын болон нийт дүнгээс харахад мэргэжлийн зөрүүтэй байдлын нөлөө мөн их байна. Утга зохиол, түүхийн мэргэжлийн оюутнуудын түвшин эдийн засаг, менежментийн болон аж үйлдвэрийн ангийн оюутнуудаас өндөр байсан бол аж үйлдвэрийн болон эдийн засаг, менежментийн ангийн оюутнуудын түвшин бараг адил түвшинд байна. Хятадхэлний түвшингийн хувьд дунд түвшний ангийн оюутнууд анхан шатны оюутнуудаас харьцангуй өндөр түвшинд байгаа нь харагдсан.

3. Хятадад суралцдаг монгол оюутнуудын соёл дамнасан хэлний дасан зохицох байдалд нөлөөлөх гадаад хүчин зүйлс

Хятад хэл суралцсан хугацаа, гэр бүлийн эдийн засгийн байдал, багш оюутнуудын харилцаа, хятад найзуудын тоо зэрэг гадаад хүчин зүйлүүдийн хоорондын зөрүүтэй байдалд хийсэн судалгааг Хүснэгт 4-өөс харна уу. Судалгаанаас харахад, суралцах хугацаа нэмэгдэхийн хэрээр хэлний дасан зохицох түвшин нэмэгдэх хандлагатай байгаа ч 1-3 жилийн дараагаас аажмаар тогтох хандлага ажиглагдсан. 1 жилээс бага хугацаанд суралцсан сурагчид бусад сурагчдаас дасан зохицох түвшин нь харьцангуй бага байна. Гэр бүлийн эдийн засгийн байдал

нь дасан зохицох түвшинд эерэг нөлөө үзүүлсэн байна. Багштайгаа харилцаа сайтай болон олон хятад найзуудтай оюутнуудын хэлний дасан зохицох түвшин нь мөн маш сайн үзүүлэлттэй байна.

Дөрөв. Судалгаанд хийсэн дүн шинжилгээ

1. Хятадад суралцдаг монгол оюутнуудын соёл дамнасан хэлний дасан зохицох байдлын ерөнхий түвшин ба тархалтын онцлог

Монгол оюутнуудын соёл дамнасан хэлний дасан зохицох байдлын онцлогоос харахад, монгол оюутнуудын хэлний дасан зохицох байдлын ерөнхий түвшин харьцангуй өндөр боловч нөлөөлөх хүчин зүйлүүдээс шалтгаалаад гарч байгаа тэнцвэртэй бус зүйлс ч мөн байна. Үүнээс дурдвал, танхимийн хэлний дасан зохицох түвшин харьцангуй сайн боловч ярианы бус хэлний түвшин харьцангуй доогуур байна. Тархалтын онцлогоос харахад, нийт түвшин эсвэл бусад чадваруудын аль нь ч байсан тархалтын түвшин хэвийн хэмжээнд байна. Судалгаанд оролцсогчид нь өвөрмонголын сургуулиудын оюутнууд бөгөөд өвөрмонгол болон монгол улс нь зэргэлдээ оршдог ойролцоо хэлээр ярьдаг болон амьдралын хэв маяг ч мөн төстэй байдаг. Иймээс сэтгэл зүйн болон соёлын хувьд ойр дөхөм байгаа нь хэлний дасан зохицох түвшинг нэмэгдүүлэхэд нөлөө үзүүлж байна. Үүнээс гадна монгол оюутнууд халуун сэтгэлтэй, шийдэмгий, өөрийгөө харуулах нээх сонирхолтой байдаг зэрэг зан төлвийн онцлог нь тэднийг харилцааны явцад өөртөө итгэлтэй, идэвхитэй, санаачлагатай байж хэлний чадамжаа ашиглахад нь ихээхэн дэмжлэг болдог. Тус судалгааны ажлын ярианы бус чадварын дасан зохицох байдал нь оюутнуудын үгийн өнгө, өргөлт, дуудлага, нүүрний хувирал, гарын хөдөлгөөн, хандлага зэргийг гаргахыг зорьсон. Соёл дамнасан харилцааны явцад ярианы бус хэл нь маш чухал үүрэгтэй боловч хэлний орчинд ойлгоход нэлээд хүндрэлтэй байдаг.

2. Хятадад суралцдаг монгол оюутнуудын соёл дамнасан хэлний дасан зохицох байдалд нөлөөлж буй хүчин зүйлсд хийсэн дүн шинжилгээ

Монгол оюутнуудын хэлний дасан зохицох байдалд хүйсийн ялгааны нөлөө их байгаа буюу эмэгтэйчүүдийн хэлний дасан зохицох түвшин харьцангуй өндөр байна. Үүнээс гадна эмэгтэйчүүд хэлийг суралцах явцдаа илүү хүчин чармайлт, цаг хугацаа зарцуулдаг нь харагдсан. Судалгаанаас эмэгтэйчүүд дуудлага, хөг, хэлзүй, үгийн сан, үгийн хэрэглээ зэрэг тал дээр буюу бүх түвшинд маш сайн үзүүлэлттэй гарсан байна.

Хэлний дасан зохицох байдалд насны зөрүүтэй байдлын нөлөө нь “U” хэлбэртэй гарсан. Oberg –н дэвшүүлсэн U хэлбэрийн муруйлтын онолоор бол шинэ соёлын орчинд орсон хүн бал сарын үе, шокны үе, дасан зохицлын үе гэсэн хөгжлийн үе шатуудыг дамждаг гэж үзсэн байдаг. Тэгвэл монгол оюутнуудын хэлний дасан зохицох байдал яг энэ хөгжлийн зарчмаар буюу анхан шатны бал сарын үед хэлний дасан зохицох чадвар маш сайн, соёлын шокны үе рүү ороод нэлээд бага үзүүлэлт гардаг ч дасан зохицлын үед түвшин буцаад өсөх байдал ажиглагдаж байна. Бакалаврын түвшний оюутнууд ярианы бус хэлний чадварын хувьд магистрын түвшний оюутнуудаас өндөр байгаа нь мөн настай холбоотой. Бакалаврын түвшин 16-29 насны хооронд бол магистр докторын түвшний оюутнууд 22-40 насны хооронд байна. Нас бага байх тусам үгийн өнгө, өргөлт, дуудлага, нүүрний хувирал, гарын хөдөлгөөн, хандлага зэрэг ярианы бус чадварын дасан зохицох түвшин нь харьцангуй өндөр байна. Унших, сонсох, бичгийн болон ярианы бус чадварын хувьд утга зохиол, түүхийн мэргэжлийн оюутнуудын хэлний дасан зохицох

түвшин бусад ангийн оюутнуудаас өндөр байгаа нь түүх, утга зохиолын ангийн оюутнуудын хятад хэл ашиглах хэрэглэх шаардлага өндөр байдагтай нь холбоотой байна. Дунд болон ахисан түвшний оюутнуудын хэлний дасан зохицох түвшин өндөр байгаа нь нийт хятад хэл суралцсан хугацаагаар зогсохгүй хятад хэл болон соёлын түвшинтэй нь мөн холбоотой юм.

Нийт хятад хэл суралцсан хугацаа нэмэгдэх тусам хэлний дасан зохицох түвшин дагаад нэмэгдэх боловч 1-3 жилийн дараагаас аажмаар тогтох буюу зарим тохиолдолд бүр буурах ч хандлага ажиглагдсан. Гадаад оюутнууд шинэ соёлд дасан зохицохдоо “Бал сарын үе”-ийг дамжин өнгөрдөг. Энэ үедээ оюутнууд шинэ хэлний орчин, шинэ соёлд маш их татагдаж сониучирхдаг тул энэ нь хэл сурахад нь түлхэц болж өгдөг байна. Түүнээс гадна найдвартай нийгмийн дэмжлэг ч мөн хятадад суралцдаг оюутнуудын соёл дамнасан дасан зохицох түвшинд чухал нөлөө үзүүлж байна. Судалгаанаас харахад, нийгмийн дэмжлэг нь гэр бүлийн гишүүдээс нөлөөлөхөөс гадна тухайн газар орны хүмүүсийн харьцаанаас ч мөн хамаардаг байна. Тухайн газар орны хүмүүстэй сайн харилцаатай тухайн газар оршин суудаг найз ихтэй хүмүүсийн хувьд дасан зохицох байдалд нь асуудал бага гардаг байна. Тус судалгаанаас харахад ч гэсэн гэр бүлийн санхүүгийн боломж сайн, багштайгаа харилцаа сайтай, олон хятад найзтай монгол оюутнуудын хувьд хэлний дасан зохицох түвшин нь маш өндөр байсан нь ажиглагдсан.

Номзүй:

1. 黄文虎. 跨文化适应的影响因素与结果变量研究 [D]. 华东师范大学, 2011.
2. 刘正光. 言语适应理论研究述评 [J]. 语言文字应用, 2001 (2).
3. Verschueren. J. Understanding Pragmatics [M]. London: Edward Arnold Publishers, 1999.
4. 兰晶, 罗迪江. 语言适应论的相关问题辨析 [J]. 成都理工大学学报:社会科学版, 2015 (1).
5. 刘萍萍. 非语言符号的话语意义研究 [J]. 辽宁行政学院学报, 2012 (1).
6. Oberg, K. Cultural Shock: Adjustment to New Cultural Environments [J]. Practical Anthropology, 1960 (7).
7. 陈慧, 车宏生, 朱敏. 跨文化适应影响因素研究述评 [J]. 心理科学进展, 2003 (6).